



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 2 сарын 24 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

VI ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын VI хурал 2020 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 14.00 цагаас Төрийн ордон дахь Шадар сайдын ажлын өрөөнд 96.5 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. БНСУ дахь Монгол Улсын иргэдтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар;
2. Коронавируст (COVID-19) халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагаас хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл;
3. БНСУ, Монгол Улс хооронд агаарын тээврээр зорчиж буй иргэдийн асуудал болон нүүрс, газрын тосны тээвэрлэлтийн бэлтгэл ажлын талаар Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан;
4. Нүүрс, газрын тосны тээвэрлэлтийг сэргээхтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар;
5. Цагаан сарын баярын өдрүүдэд авто замын хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, нийслэлийн Онцгой комиссын дарга С.Амарсайхан нарын мэдээллийг сонсов.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

- а) БНСУ-д сүүлийн өдрүүдэд эрчимтэй нэмэгдэж буй коронавируст (COVID-19) халдварын тархалтын талаар Улсын онцгой комиссоор хэлэлцээд болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсаас БНСУ-ын Сөүл, Бусан хот руу үйлддэг 2

талын шууд нислэгийг 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс 3 дугаар сарын 2-ны өдрийг дуустал хугацаанд түр зогсоох нь зүйтэй гэж;

б) Цаашид нөхцөл байдалтай холбогдуулан хугацааг сунгах эсэх асуудлыг тухайн үед нь хэлэлцэн шийдвэрлэхээр тус тус тогтов.

Нэг. Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгаланд:

1.1. БНСУ-руу үйлдэх 2 талын нислэгийг түр хугацаагаар зогсоосонтой холбогдуулан зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

1.2. БНСУ-аас Монгол Улс, Монгол Улсаас БНСУ-ын чиглэлд агаарын тээврээр үйлчлүүлэхээр нислэгийн тийз худалдан авсан иргэдийн тийзийг 2020 оны 3 дугаар сарын 2-ны өдрийг дуустал шимтгэлгүйгээр буцаах, хугацааг хойшлуулах, хязгаарлалтын хугацаа дууссаны дараа эхний ээлжинд тийзээ ашиглах боломжоор хангах;

1.3. Гадаадын бусад улсаас БНСУ-аар дамжин ирж буй зорчигчдыг “Инчеон” олон улсын нисэх онгоцны буудалд төвлөрүүлэн, тусгай нислэгээр татан авах ажлыг 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс 3 дугаар сарын 2-ны өдрийн хооронд зохион байгуулах;

1.4. Монгол Улсаас БНСУ-руу үйлдэх 2 талын шууд нислэгийг хэвийн горимд шилжүүлэхийн өмнө коронавируст (COVID-19) халдвараас урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах талаар БНСУ-ын талтай зөвшилцөх, холбогдох арга хэмжээ авах;

Хоёр. Сангийн сайд Ч.Хүрэлбаатар

Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан нарт:

2.1. Гадаад орнуудаас 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс 3 дугаар сарын 2-ны өдрийг дуустал БНСУ-ын “Инчеон” нисэх онгоцны буудлаар дамжин ирж буй Монгол Улсын иргэдийг тусгай нислэгээр татан авах хүртэлх хугацааны зочид буудлын төлбөрийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны төсвийн багцад зохицуулалт хийх замаар санхүүжүүлэх боломжийг судлан үзэж, Засгийн газарт танилцуулах;

Гурав. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Д.Чинзориг,

Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөн нарт:

3.1. Онгоцны нислэгийг зогсоосон дээрх хугацаанд хоёр улсын Хөдөлмөрийн яам хоорондын тохиролцооны дагуу БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй Монгол

Улсын иргэдийн болон Монгол Улсад байгаа БНСУ-ын иргэдийн визний хугацаа дуусгавар болсон тохиолдолд сунгах асуудлыг тус тус шийдвэрлэх;

3.2. Гашуунсухайт-Ганц мод боомтыг уртасгасан горимоор ажиллуулах асуудлыг БНХАУ-ын талд дипломат шугамаар тавьж шийдвэрлүүлэх;

Дөрөв. Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар,

холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт:

4.1. Ариутгал, халдваргүйтгэлийн ажилд шаардагдах санхүүжилтийг “Эрдэнэс Таван толгой” ХК, “Эрдэнэс Таван толгой майнинг” ХХК, “Петрочайна дачин тамсаг” ХХК, “Доншен газрын тос Монгол” ХХК болон бусад уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж буй компаниудаар шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;

4.2. Цагаан хад дахь гаалийн хяналтын талбайд нүүрсний хуримтлал бий болсон тул тээвэрлэлтийг зохицуулах арга хэмжээ авч ажиллах;

4.3. Хилээр нэвтэрч буй тээврийн хэрэгслийн тоо, ачааны хэмжээтэй уялдуулан гаалийн бүрдүүлэлтийг хийж, дараалал үүсгэхгүйгээр Цагаан хад-Гашуунсухайт чиглэлийн тээвэрлэлтийг зохион байгуулах;

Тав. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү,

Гаалийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,

Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн,

Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатар

Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар нарт

5.1. Нүүрс болон газрын тосны тээвэрлэлтийг сэргээх үйл ажиллагааны хүрээнд Баянхошуу, Бичигт, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад ариутгал, халдваргүйтгэл хийх ажлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Петрочайна дачин тамсаг” ХХК, “Доншен газрын тос Монгол” ХХК болон бусад төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран зохион байгуулах;

5.2. Баянхошуу, Бичигт, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлж, тээвэрлэлтэд ажиллаж байгаа жолооч нарын эрүүл мэндэд хяналт тавьж ажиллах;


5.3. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах заавар, журмыг боловсруулж, аж ахуйн нэгж, байгууллагуудаар мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

Зургаа. Аймаг, нийслэлийн Засаг дарга,

Онцгой комиссын дарга нарт:


6.1. Коронавируст халдвар (COVID-19)-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай авах зорилгоор эрүүл мэнд, нийгмийн халамжийн даатгалаар үйл ажиллагаа явуулдаг амралт, сувиллын газар, хувийн эмнэлгийн байгууллагуудын эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангуулж, шаардлагатай тохиолдолд ашиглахыг тус тус үүрэг болгов.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТҮВШИН

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ, ОНЦГОЙ БАЙДЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН